



**ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ГИШҮҮДИЙН АЖЛЫН
ҮНЭЛГЭЭГ ДҮГНЭХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “АТБС ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагаа болон гишүүдийн ажлын үнэлгээг хийх, түүнийг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТУЗ-ийн гишүүдийн эрх тэгш, ил тод байдал, зохистой засаглалыг хэрэгжүүлэх, шударга ёсыг хангах, хараат бус байх, нууцыг чандлан хадгалах зарчмыг баримтална.
- 1.3. Энэ журам нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль, журмыг мөрддөг болгоно.

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

- 2.1. ТУЗ-ийн үйл ажиллагаа болон гишүүдийн ажлын үнэлгээг нийт гишүүдийн дунд үнэлгээний хуудас ашиглан асуулгын аргаар явуулна.
 - 2.1.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх хүснэгт – Хавсралт № 1
 - 2.1.2. ТУЗ-ийн гишүүдийн ажлыг үнэлэх хүснэгт – Хавсралт № 2
- 2.2. Үнэлгээг ТУЗ-ийн гишүүдийн болон хараат бус гишүүнээс авна.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ДҮГНЭЛТ

- 3.1. Үнэлгээг жилд нэг удаа хийнэ.
- 3.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь үнэлгээний хуудсыг бэлтгэж, гишүүдээс үнэлгээ авах талаар гишүүдэд мэдээлэл хүргүүлэн, гишүүн тус бүрээр үнэлгээний хуудсыг бөглүүлэн авна.
- 3.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь гишүүдийн үнэлгээг нэгтгэн ТУЗ-ийн даргад танилцуулна.
- 3.4. ТУЗ-ийн дарга нь гишүүдийн өгсөн үнэлгээнд дүн шинжилгээ хийж ТУЗ-ийн гишүүд болон ХЭ-ийн хуралд танилцуулна.
- 3.5. Үнэлгээний дүн нь ББСБ-ын нууцад хамаарна.

ДӨРӨВ. ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүд нь үнэлгээний асуулгыг нэг бүрчлэн анхааралтай, сайтар уншиж, үнэн зөвөөр бөглөх үүрэгтэй.
- 4.2. ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүн нь ажлын үнэлгээний хуудсыг заавал бөглөж үнэлгээ өгөх үүрэгтэй.
- 4.3. Үнэлгээнд оролцох боломжгүй болсон тохиолдолд тухайн шалтгаанаа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга урьдчилан мэдэгдэж, ажлын үнэлгээний хуудсыг урьдчилан авч бөглөх.

- 4.4. ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга гишүүн бүрээр үнэлгээний хуудсыг бөглүүлэн авч, үнэлгээг нэгтгэн ТҮЗ-ийн даргад танилцуулах ба үнэлгээтэй холбоотой мэдээллийг нууцлан хадгалах үүрэгтэй.
- 4.5. ТҮЗ-ийн дарга гишүүдийн өгсөн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, ТҮЗ-ийн нийт гишүүд, ХЭ-дэд танилцуулах, үнэлгээтэй холбоотой мэдээллийг нууцлан хадгалах үүрэгтэй.
- 4.6. ТҮЗ-ийн гишүүд, хараат бус гишүүд нь үнэлгээний асуулгыг бөглөх явцад тодорхой бус, ойлгомжгүй асуултын талаар тодруулга хийж, асуулт тавих эрхтэй.

ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1. ТҮЗ-ийн гишүүд нь ТҮЗ-ийн үйл ажиллагааны журам болон Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн гэрээний дагуу ББСБ болон холбогдох этгээдүүдийн өмнө хариуцлага хүлээнэ.

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ХҮСНЭГТ

Дараах хүснэгтэд дурдсан асуулт бүрт ТҮЗ-ийн гишүүд өөрсдийн үнэлгээг дор дурдсан байдлаар өгнө.

| | |
|---|--------------------------------|
| 1 | Нэлээд сайжруулах шаардлагатай |
| 2 | Сайжруулах шаардлагатай |
| 3 | Дунд зэрэг |
| 4 | Сайн |
| 5 | Маш сайн |

Үнэлгээний хүснэгтэд ТУЗ-ийн гишүүдийн нэр бичигдэхгүй.

НЭГ. Ерөнхий үйл ажиллагаа ба бүрэн эрхийн хэрэгжилт

| № | Асуултууд | Үнэлгээ | | | | |
|---|---|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Компани болон түүний ХЭ-ийн сонирхлыг хамгаалахад ТУЗ үйл ажиллагаагаа хангалттай чиглүүлж байсан уу? | | | | | |
| 2 | ТУЗ шийдвэр гаргахдаа бизнесийн өртгийг нэмэгдүүлэх болон ХЭ-ийн бусад сонирхлыг хангахад чиглэгдэж байсан уу? Та үүнийг яаж үзэж байна? | | | | | |
| 3 | ТУЗ-ийн бүрэн эрх амьдрал дээр ХЭХ болон ГҮ-ын бүрэн эрхээс хэр ялгагдан зааглагдаж байсан бэ? | | | | | |
| 4 | Та ТУЗ-ийг өөрийн үүрэг роль, бүрэн эрх болон гол зорилтуудаа бүрэн хэмжээнд ойлгож ажиллаж байгаа гэж үзэж байна уу? | | | | | |
| 5 | ТУЗ бүтэн жилийн туршид гол зангилаа асуудлуудыг шийдэхдээ компанийн үнэт зүйл, алсын хараа, стратеги зорилтуудыг хэр мэдэж ойлгосон бэ? | | | | | |
| 6 | ТУЗ компанийн үйл ажиллагааг өрөнхий удирдлагаар хангах болон түүний стратегийг тодорхойлох өөрийн үргээ хэр үр ашигтай хэрэгжүүлж байна? | | | | | |
| 7 | ТУЗ компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тавих бололцоот хэрэгслүүд ашиглан хэрэгжүүлж чадаж байгаа юу? | | | | | |
| 8 | ТУЗ компанийн ГҮ-ын ажлыг дүгнэх өөрийн үргээ хэр сайн хэрэгжүүлж байгаа вэ? | | | | | |

ХОЁР. ТУЗ-ийн гишүүд

| № | Асуултууд | Үнэлгээ | | | | |
|---|---|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Гишүүдийн тоо шаардлага хангаж байгаа юу? | | | | | |
| 2 | ТҮЗ-ийн болон түүний хороодын удирдлага хэр үр ашигтай ажиллаж байна? | | | | | |
| 3 | ТҮЗ-ийн гишүүдийн тоо тэдний мэдлэг, туршлага, чадвар болон бусад байх ёстой чанарын талаар боловсруулсан, хэрэгжүүлсэн, төлөвлөж буй бодлого байгаа юу? | | | | | |
| 4 | Компанийн стратегийг боловсруулах болон үйл ажллагаанд шаардлагатай хяналтыг хэрэгжүүлэхэд одоогийн ТҮЗ-ийн гишүүдийн мэдлэг, чадвар болон ТҮЗ-ийн бүтэц хангалттай юу? | | | | | |
| 5 | ТҮЗ-ийн гишүүдийн хамтын ажиллагаа хэр үр ашигтай вэ? Тухайлбал, ТҮЗ хамтын байгууллагын хувьд хэр үр дүнтэй ажиллаж байна? Тодорхой чухал санал гаргасан гишүүдийг урамшуулдаг уу? | | | | | |
| 6 | ТҮЗ-ийн хараат бус гишүүн бодит байдалд хараат бус байж чаддаг уу? | | | | | |

ГУРАВ. ТУЗ-ийн хороод

| № | Асуултууд | Үнэлгээ | | | | |
|---|--|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | ТҮЗ-ийн дэргэд шаардлагатай хороод ажилладаг уу? | | | | | |
| 2 | Хороод хэр үр ашигтай ажиллаж байна гэж үздэг вэ? Тэд шаардлагатай зөвлөмж өгч чаддаг уу? | | | | | |
| 3 | Хорооны гишүүд тухайн хорооныхоо хариуцсан чиглэлээр хангалттай мэдлэг чадвар, туршлагатай юу? | | | | | |
| 4 | Хорооны гишүүн бус ТҮЗ-ийн гишүүд хорооны шийдвэрийн талаар мэдээлэл хэр авдаг вэ? | | | | | |

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

| № | Асуултууд | Үнэлгээ | | | | |
|----|---|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | ТУЗ чухал асуудлаа хэр зөв тодорхойлж чаддаг вэ? Ийм асуудлуудыг хэлэлцэх төлөвлөгөө график байдаг уу? | | | | | |
| 2 | Та ТУЗ-ийн хуралд сайн бэлдэхийн тулд хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг хангалттай цаг хугацаанд урьдчилан авдаг уу? | | | | | |
| 3 | Дээрх мэдээллийг хурлаас өмнө агуулга чанарын хувьд авч чаддаг уу? | | | | | |
| 4 | ТУЗ-ийн хурал хэлэлцэж буй асуудлаар гишүүд хоорондоо нээлттэй саналаа солилцож хэлэлцэж цаг тухайд нь шийдвэртээ гаргаж чаддаг уу? | | | | | |
| 5 | ТУЗ-ийн хуралд асуудал танилцуулагч шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл өгч чаддаг уу? | | | | | |
| 6 | Асуудал хэлэлцэх ба танилцуулах хугацааны хуваарилалт хэр зөв явагддаг вэ? | | | | | |
| 7 | ТУЗ-ийн хурлын зэрэгцээ компанийн албан хаагчидтай мэдээлэл солилцоо бололцоо байдаг уу? | | | | | |
| 8 | ГУ-ын ажлыг дүгнэхийн тул ТУЗ компанийн үр ашгийн үзүүлэлтийг тодорхойлдог уу? | | | | | |
| 9 | ТУЗ-ийн хурлын өмнө танд танилцуулсан санхүүгийн мэдээлэл нь компанийн чухал асуудал болон хэтийн чиглэлийг ойлгоход хангалттай мэдээлэл болдог уу? | | | | | |
| 10 | Танд өгч буй санхүүгийн мэдээллийн хэлбэр нь компанийн чухал асуудал ба хэтийн чиглэлийг салгасан байдаг уу? | | | | | |
| 11 | ТУЗ болон ГУ нь компанийн үйл ажиллагаанд гол нөлөө үзүүлэх эрсдэлд анхаарлаа төвлөрүүлж ажилладаг гэж хэлж чадах уу? | | | | | |
| 12 | ТУЗ-д эрсдэлийг хянах систем байгаа юу? | | | | | |
| 13 | Шинээр сонгогдсон гишүүдэд компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн ажиллах журмыг танилцуулах мэдээлэл бий юу? | | | | | |

ТАВ. ТҮЗ-ИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

| № | Асуултууд | Үнэлгээ | | | | |
|---|---|---------|---|---|---|---|
| 1 | Компанитай холбоотой асуудал үүсэхэд хүлээх үүргийн талаар мэдээлэл өгсөн үү, өгсөн бол хэр хангалттай байсан бэ? | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2 | ТУЗ-ийн гишүүдэд өөрийн хяналтын үүргийг гүйцэтгэхэд компанийн үйл ажиллагаа түүний онцлогийн талаар мэдэж авахад хангалттай хугацаа зарцуулсан уу? | | | | | |
| 3 | ТУЗ-ийн гишүүдээс ГҮ-ын ажиллагаанд өгч буй зөв шүүмжлэлийг хүлээн авч буй байдал хангалттай байдаг уу? | | | | | |
| 4 | ТУЗ-ийн гишүүд компанийтай өөрийн хийсэн хэлэцээр дэх сонирхлын талаар мэдээлэлдэг үү? Түүнийг хэлэлцэхэд санал өгхөөс татгалздаг уу? | | | | | |
| 5 | Таны хариуцлагын талаар компани хамгаалалтын ямар нэг хэлбэр илэрхийлдэг үү? | | | | | |

ТУЗ-ийн уйл ажсиллагаа болон гишүүдийн ажлын үнэлгээг
дүгнэх журмын Хавсралт №2

**ТУЗ-ИЙН ГИШҮҮД БОЛОН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЖЛЫГ ҮНЭЛЭХ ХҮСНЭГТ**

Дараах хүснэгтэд дурдсан асуулт бүрт ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга өөрөөсөө бусад гишүүнд
дор дурдсан байдлаар үнэлгээ өгнө.

| | |
|---|--------------------------------|
| 1 | Нэлээд сайжруулах шаардлагатай |
| 2 | Сайжруулах шаардлагатай |
| 3 | Дунд зэрэг |
| 4 | Сайн |
| 5 | Маш сайн |

ТУЗ-ийн гишүүн..... овогтой.....-ийн үнэлгээний хуудас

| № | ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын ажлыг дүгнэх үзүүлэлт | 1 | 2 | 3 | 4 | 5 |
|----|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| 1 | Мэргэжлийн дадлага | | | | | |
| 2 | Салбарын мэдлэг | | | | | |
| 3 | Мэргэжил | | | | | |
| 4 | Ажил хэргийн хэлэлцүүлэг | | | | | |
| 5 | Стратеги хандлага | | | | | |
| 6 | Шударга байдал | | | | | |
| 7 | Хуралд оролцох оролцоо | | | | | |
| 8 | Хуралд бэлтгэх байдал | | | | | |
| 9 | Багаар ажиллах чадвар | | | | | |
| 10 | Идэвхтэй байдал | | | | | |
| 11 | Ерөнхий оролцоо | | | | | |